



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 1/09

Мандалговь

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дах заалт, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 4 дэх заалт, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 527 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 691 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



С.ХУЛАН

482412033